

ТАНИЛЦУУЛГА

*Татварын ерөнхий хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.21-д “Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4 дүгээр хавсралтад заасан Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн жагсаалтын 6-д “Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, холбогдох бусад татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэж заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, татварын таатай орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан иргэд, аж ахуйн нэгжүүд татвар, гаалийн хууль тогтоомжийг сайн дураараа мөрдөх явдлыг дэмжих, татвар, гаалийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, татвар төлөгчдөд тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Татварын багц хуулийн 2019 оны шинэчлэл нь бизнес эрхлэлт, жижиг дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, хялбаршуулах, татвараас зугтах, зайлсхийх явдлын эсрэг тэмцэх, худалдааг хөнгөвчлөх гэсэн үндсэн зорилготой байсан. Татварын үйл ажиллагааг цахимжуулах, хялбаршуулах зорилгын хүрээнд сүүлийн жилүүдэд Монгол Улсын татварын албаны цахимжилт эрчимтэй хөгжиж, татвар төлөгчийн бүртгэл, тайлагнал, төлөлт бүрэн цахимжсанаар хүний оролцоо багасах нөхцөл бүрдсэн.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг, бизнесийн харилцаа өргөжин тэлж, техник, технологийн хөгжил хурдацтай өрнөхийн хэрээр татварын үйл ажиллагааны цахимжилтыг дараагийн түвшинд хүргэж, хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан, хүний оролцоо багатай, бүрэн цахимжсан системд шилжүүлэх шаардлага бий болж байна.

Олон улсын валютын сангаас 2022 онд хийсэн “Монгол Улс: Татварын албаны үйл ажиллагааг үнэлэх хэрэгсэл Гүйцэтгэлийн үнэлгээний тайлан”-д дурдсанаар Монгол Улсын татварын албаны үйл ажиллагааг нийт 32 үзүүлэлтээр үнэлэхэд үйл ажиллагааны эрсдэл, татварын тайлангийн хамрагдалт, татварын үнэн зөв

тайлагнал, татварыг хугацаанд нь төлж буй байдал зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд хангалтгүй үнэлгээ авсан байна.

Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох зорилгоор 2022 онд жижиг, бичил сегментийн аж ахуйн нэгж болон иргэдээс нийт 78 үзүүлэлтэд үндэслэн судалгаа авсан. Судалгаагаар татвар төлөгчдийн 18 хувь нь сургалт, зөвлөгөө, заавар, зөвлөмж өгдөггүй гэж, 25 хувь нь татвар төлөх хугацаа уян хатан биш гэж дүгнэсэн. Мөн татвар төлөгчид санал хүсэлтэд хариу өгөх үзүүлэлтэд бага оноо өгч, мэдээлэл өгөх, зөвлөх үйлчилгээг сайжруулах, мэдээллийг энгийн ойлгомжтой болгох, татварын албаны харилцах үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд цахим төлбөрийн баримтын системийг нэвтрүүлснээр нийт хэрэглэгчийн тоо 2.3 саяд хүрч, сард дунджаар хэвлэгдэж байгаа баримтын үнийн дүн 6.2 их наяд төгрөгт хүрч, 37.3 сая баримт хэвлэсэн статистик тоон үзүүлэлттэй байна. Мөн цахим төлбөрийн баримтын системийг ашиглан хөрөнгийн татварын нэхэмжлэхээ төлөх боломж бүрдсэн билээ.

Цаашид энэхүү хөгжлийг улам бүр нэмэгдүүлж, татварын эрсдэлийг цахим систем өөрөө үнэлж, эрсдэлтэй татвар төлөгчдөд эрсдэлийг урьдчилан анхааруулдаг, сануулдаг, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргадаг тогтолцоонд шилжих нь зүйтэй байна. Ингэснээр татварын албаны хяналт шалгалтын тоог бууруулахаас гадна татвар төлөгчдөд учирдаг хүндрэл, зөрчлийн тоог бууруулах эерэг үр нөлөөтэй юм.

Түүнчлэн, олон улсын чиг хандлагаас харахад сүүлийн жилүүдэд татварын албаны хяналтын механизмыг хялбаршуулах, татвар төлөгчдөд зөвлөн туслах үйлчилгээг сайжруулах чиглэлээр томоохон шинэчлэлүүд хийгдэж байна. Тухайлбал, Шинэ Зеланд, Австрали, Канад, Финланд зэрэг улс орнууд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх механизмыг нэвтрүүлж байна. Эдгээр улсуудад татвар төлөгчийг зөрчил гаргасны дараа шийтгэл хүлээлгэх бус, зөрчил гарахаас нь өмнө урьдчилан мэдээлж, тайлан гаргах, татвар төлөх үйл явцыг хялбар, ойлгомжтой болгох бодлого баримталдаг. Монгол Улс мөн энэ чиг хандлагыг баримталж, цахим системийн хөгжлийг ашиглан зөвлөн туслах үйлчилгээ, автомат хяналтын тогтолцоог нэвтрүүлж, татварын орчныг хялбаршуулж, сайжруулах шаардлага үүсээд байна.

Хууль батлагдсанаар татвар төлөгчдөд үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, гааль, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө авах боломж хялбар болно. Үүний үр дүнд татвар төлөгч, татвар, гаалийн байгууллагын хооронд үүсдэг хуулийн хэрэглээтэй холбоотой маргаан багасаж, татварын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

Татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татварын хууль тогтоомжийг сайн дураар дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх нь зөвлөн туслах үйлчилгээний нэг гол зорилго юм. Үүний хүрээнд татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин буурах болон татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл

үүссэн тохиолдолд татварын алба урьдчилан сануулж, татвар төлөгчид алдаа, зөрчлөө өөрөө засах, арилгах боломжийг олгох юм. Энэ нь татварын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, татварын орчны тогтвортой байдлыг хангах, татвар төлөгчид хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Түүнчлэн, татварын алба татвар төлөгчийг алдаа гаргасны дараа хянан шалгаж акт, торгууль тавих бус, татварын тайланг залруулах хугацааг сунгаж, татвар төлөгчдөд итгэл үзүүлж, татвар хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагаа илүү үр дүнтэй, татвар төлөгчдөд чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөлийг бий болгоход чухал нөлөөтэй.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.21-д “Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4 дүгээр хавсралтад заасан Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн жагсаалтын 6-д “Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, холбогдох бусад татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэж заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, татварын таатай орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан иргэд, аж ахуйн нэгжүүд татвар, гаалийн хууль тогтоомжийг сайн дураараа мөрдөх явдлыг дэмжих, татвар, гаалийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, татвар төлөгчдөд тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Татварын багц хуулийн 2019 оны шинэчлэл нь бизнес эрхлэлт, жижиг дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, хялбаршуулах, татвараас зугтах, зайлсхийх явдлын эсрэг тэмцэх, худалдааг хөнгөвчлөх гэсэн үндсэн зорилготой байсан. Татварын үйл ажиллагааг цахимжуулах, хялбаршуулах зорилгын хүрээнд сүүлийн жилүүдэд Монгол Улсын татварын албаны цахимжилт эрчимтэй хөгжиж, татвар төлөгчийн бүртгэл, тайлагнал, төлөлт бүрэн цахимжсанаар хүний оролцоо багасах нөхцөл бүрдсэн.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг, бизнесийн харилцаа өргөжин тэлж, техник, технологийн хөгжил хурдацтай өрнөхийн хэрээр татварын үйл ажиллагааны цахимжилтыг дараагийн түвшинд хүргэж, хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан, хүний оролцоо багатай, бүрэн цахимжсан системд шилжүүлэх шаардлага бий болж байна.

Олон улсын валютын сангаас 2022 онд хийсэн “Монгол Улс: Татварын албаны үйл ажиллагааг үнэлэх хэрэгсэл Гүйцэтгэлийн үнэлгээний тайлан”-д дурдсанаар Монгол Улсын татварын албаны үйл ажиллагааг нийт 32 үзүүлэлтээр үнэлэхэд үйл ажиллагааны эрсдэл, татварын тайлангийн хамрагдалт, татварын үнэн зөв

тайлагнал, татварыг хугацаанд нь төлж буй байдал зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд хангалтгүй үнэлгээ авсан байна.

Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох зорилгоор 2022 онд жижиг, бичил сегментийн аж ахуйн нэгж болон иргэдээс нийт 78 үзүүлэлтэд үндэслэн судалгаа авсан. Судалгаагаар татвар төлөгчдийн 18 хувь нь сургалт, зөвлөгөө, заавар, зөвлөмж өгдөггүй гэж, 25 хувь нь татвар төлөх хугацаа уян хатан биш гэж дүгнэсэн. Мөн татвар төлөгчид санал хүсэлтэд хариу өгөх үзүүлэлтэд бага оноо өгч, мэдээлэл өгөх, зөвлөх үйлчилгээг сайжруулах, мэдээллийг энгийн ойлгомжтой болгох, татварын албаны харилцах үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд цахим төлбөрийн баримтын системийг нэвтрүүлснээр нийт хэрэглэгчийн тоо 2.3 саяд хүрч, сард дунджаар хэвлэгдэж байгаа баримтын үнийн дүн 6.2 их наяд төгрөгт хүрч, 37.3 сая баримт хэвлэсэн статистик тоон үзүүлэлттэй байна. Мөн цахим төлбөрийн баримтын системийг ашиглан хөрөнгийн татварын нэхэмжлэхээ төлөх боломж бүрдсэн билээ.

Цаашид энэхүү хөгжлийг улам бүр нэмэгдүүлж, татварын эрсдэлийг цахим систем өөрөө үнэлж, эрсдэлтэй татвар төлөгчдөд эрсдэлийг урьдчилан анхааруулдаг, сануулдаг, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргадаг тогтолцоонд шилжих нь зүйтэй байна. Ингэснээр татварын албаны хяналт шалгалтын тоог бууруулахаас гадна татвар төлөгчдөд учирдаг хүндрэл, зөрчлийн тоог бууруулах эерэг үр нөлөөтэй юм.

Түүнчлэн, олон улсын чиг хандлагаас харахад сүүлийн жилүүдэд татварын албаны хяналтын механизмыг хялбаршуулах, татвар төлөгчдөд зөвлөн туслах үйлчилгээг сайжруулах чиглэлээр томоохон шинэчлэлүүд хийгдэж байна. Тухайлбал, Шинэ Зеланд, Австрали, Канад, Финланд зэрэг улс орнууд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх механизмыг нэвтрүүлж байна. Эдгээр улсуудад татвар төлөгчийг зөрчил гаргасны дараа шийтгэл хүлээлгэх бус, зөрчил гарахаас нь өмнө урьдчилан мэдээлж, тайлан гаргах, татвар төлөх үйл явцыг хялбар, ойлгомжтой болгох бодлого баримталдаг. Монгол Улс мөн энэ чиг хандлагыг баримталж, цахим системийн хөгжлийг ашиглан зөвлөн туслах үйлчилгээ, автомат хяналтын тогтолцоог нэвтрүүлж, татварын орчныг хялбаршуулж, сайжруулах шаардлага үүсээд байна.

Хууль батлагдсанаар татвар төлөгчдөд үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, гааль, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө авах боломж хялбар болно. Үүний үр дүнд татвар төлөгч, татвар, гаалийн байгууллагын хооронд үүсдэг хуулийн хэрэглээтэй холбоотой маргаан багасаж, татварын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

Татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татварын хууль тогтоомжийг сайн дураар дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх нь зөвлөн туслах үйлчилгээний нэг гол зорилго юм. Үүний хүрээнд татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин буурах болон татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл

үүссэн тохиолдолд татварын алба урьдчилан сануулж, татвар төлөгчид алдаа, зөрчлөө өөрөө засах, арилгах боломжийг олгох юм. Энэ нь татварын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, татварын орчны тогтвортой байдлыг хангах, татвар төлөгчид хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Түүнчлэн, татварын алба татвар төлөгчийг алдаа гаргасны дараа хянан шалгаж акт, торгууль тавих бус, татварын тайланг залруулах хугацааг сунгаж, татвар төлөгчдөд итгэл үзүүлж, татвар хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагаа илүү үр дүнтэй, татвар төлөгчдөд чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөлийг бий болгоход чухал нөлөөтэй.

Хуулийн төсөлд дараах арга хэмжээг зохицуулахаар тусгасан болно. Үүнд:

1. Гааль, татварын албаны зөвлөн туслах үйлчилгээг татвар төлөгчдөд үзүүлэхтэй холбоотой өөрчлөлт. Гааль, татварын албаны зөвлөн туслах үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, татвар төлөгчдөд хууль тогтоомжийн талаарх мэдээллийг илүү хүртээмжтэйгээр хүргэх, татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэхээр хуулийн төслийг боловсруулсан. Тухайлбал:

- Татварын алба татвар төлөгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, тэдгээрт үүсдэг нийтлэг эрсдэлийн мэдээллийг агуулсан гарын авлага, заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, танхимын болон цахим хэлбэрийн сургалтад хамруулах;
- Татварын төлөгчдийн татварын боловсролыг дээшлүүлэх, татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор холбогдох ажлыг зохион байгуулж, зөвлөмж гаргах;
- Татвар төлөгчийн гаргасан зөвлөн туслах үйлчилгээ авахтай холбоотой гаргасан хүсэлтэд үндэслэн тухайн асуудлаар бусад байгууллага, худалдааны танхим, мэргэжлийн холбоодыг хамруулан хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж, холбоотой мэдээллийг татварын албаны цахим хуудсанд байршуулах;
- Татвар төлөгчийн хүсэлтээр татварын бүртгэл, тайлагнал, төлөлтийн талаар зөвлөгөө өгөх, татварын хууль тогтоомжийн өөрчлөлтийг тухай бүр мэдээлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар хиймэл оюун ухаан, их өгөгдөл ашиглан зөвлөгөө өгөх системийг бий болгох зэрэг өөрчлөлтүүд.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл, 4 дүгээр зүйлд тус тус тусгалаа.

2. Татвар төлөгчдийн хууль сахин мөрдөх байдлыг дэмжихтэй холбоотой өөрчлөлт. Хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, урамшуулах, татвар төлөгчийг татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор гааль, татварын алба татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг тодорхойлно. Хууль даган мөрдөлтийн түвшин нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг хойшлуулах, татварын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, татвар төлөгчийг татварын хяналт шалгалтад орохоос урьдчилан сэргийлэх зэрэг зэрэг нөлөөтэй юм.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлд тус тус тусгалаа.

3. Гааль, татварын албаны үйл ажиллагааг уялдуулж, нээлттэй ил тод болгох, татвар төлөгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой өөрчлөлт. Бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор гааль, татварын албаны үйл ажиллагааг хялбаршуулж, хяналт шалгалтын давхардлыг арилгах, олон нийтэд нээлттэй болгох, татварын тайлагнал, төлбөрийн баримтын зохицуулалтыг нарийвчилж, татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлд тус тус тусгалаа.

4. Гааль, татварын албаны цахим системтэй холбоотой үйл ажиллагааны өөрчлөлт. Гааль, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх боломж болон бусад холбогдох асуудлаар татвар төлөгч, иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор хиймэл оюун ухаан болон их өгөгдөлд суурилсан, 24 цагийн турш тасралтгүй ажиллах автомат хариулагчийг ажиллуулах, хүний оролцоо багатай, бүрэн цахимжсан системд шилжинэ.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийг 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлд тус тус тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

---oOo---

INTRODUCTION

On Draft Law to Amend the General Tax Law

The Section 5.2.21 of the long-term development policy of Mongolia "Vision 2050", approved by Resolution No. 52 of 2020 of the State Great Khural of Mongolia, aims to ensure the stability of state and tax policy and create a favorable environment for attracting and protecting investments.

In Annex 4 of "New Recovery Policy" approved by Resolution No. 106 of 2021 of the State Great Khural of Mongolia lists amendments to the Entity Income Tax Law, Personal Income Tax Law, and other tax laws among the urgent draft laws for discussion by the State Great Khural.

Mongolian Government Action Plan for 2024-2028, approved by State Great Khural Resolution No. 21 in 2024, calls for tax and social insurance reforms (Annex 1, Section 3.2.1) and specifically aims to "gradually align the tax environment with international standards and improve the e-tax system" (Annex 1, Section 3.2.1.2).

To achieve these objectives, a draft law amending the Law on General Tax will be developed to foster a more favorable tax environment, encourage voluntary compliance, expand taxpayer advice and assistance services, and address common taxpayer issues.

The 2019 tax reform package aims to promote business activity, support SMEs, digitalize and simplify tax processes, combat tax evasion and avoidance, and facilitate trade. As part of this digitalization effort, the Mongolian tax administration has rapidly modernized its systems, fully digitizing taxpayer registration, reporting, and payment, thereby reducing human involvement.

With the rapid expansion of economic and business activities and advancements in technology, it is now necessary to further enhance the digitalization of tax administration by adopting artificial intelligence and big data-based solutions, transitioning to a fully automated system with minimal human intervention.

According to the 2022 "Mongolia: Tax Administration Diagnostic Assessment Tool Performance Assessment Report" conducted by the International Monetary Fund (IMF), the tax administration of Mongolia was evaluated based on 32 indicators. Mongolia scored low on indicators related to operational risk, tax reporting coverage, accuracy of tax reporting, and timely tax payments.

A 2022 Asian Development Bank-financed survey assessed taxpayer satisfaction among small, micro, and individual taxpayers across 78 indicators. The survey results revealed that 18% of taxpayers reported receiving no training, guidance, or recommendations, while 25% expressed dissatisfaction with the inflexibility of tax payment deadlines. Taxpayers also expressed dissatisfaction with responsiveness to feedback and

recommended simpler, more understandable advice and assistance, along with enhanced communication services from tax authority.

Since its introduction over 10 years ago, the e-invoice system has garnered 2.3 million users, processing an average monthly transaction volume of 6.2 trillion MNT and 37.3 million invoices. Taxpayers can now also use the system to pay property taxes.

Future development should focus on enabling the tax system to independently assess risks, provide early warnings to high-risk taxpayers, and embrace datadriven decision making. This would reduce the number of tax audits and inspections while reducing taxpayer difficulties and violations.

Moreover, recent global trends indicate that significant reforms have been made to reduce tax inspections and improving taxpayer support. Countries such as New Zealand, Australia, Canada, and Finland have introduced mechanisms to support taxpayers in complying with tax laws, offering information, and preventing potential risks. Instead of imposing penalties after violations, these nations focus on strategies such as making tax reporting and payment processes as simple and transparent as possible. Mongolia is also embracing this trend by leveraging the development of digital systems to improve taxpayer advice and assistance, implement automated control mechanisms, and streamline and simplify the tax environment.

Once the proposed amendments are enacted, taxpayer access to advisory services will improve, making it easier to obtain the necessary information and guidance on customs and tax legislation. As a result, legal disputes between taxpayers and tax or customs authorities will decrease, while measures to prevent tax violations will be strengthened.

A primary objective of a taxpayer advice and assistance services is to proactively prevent taxpayers from potential risks and to support their voluntary compliance with tax legislation. In this context, If the taxpayer compliance score declines or circumstances arise that could negatively affect tax risk scores, the tax authority will issue a prior warning, giving the taxpayer an opportunity to correct or resolve any errors or violations. This will contribute to the prevention of tax violations, and enabling taxpayers to carry out their operations in a responsible and transparent manner.

Additionally, instead of conducting inspections and imposing fines after a taxpayer makes a mistake, the tax administration will be able to extend the time for correcting tax reports, demonstrating trust in taxpayers. This approach plays a key role in creating conditions for more efficient tax collection and auditing activities, reducing the burden on taxpayers and promoting a more risk-based approach.

The draft law includes the following measures:

- 1. Amendments Concerning the Provision of Taxpayer advice and assistance Services by the Customs and Tax Administration.** The draft law seeks to broaden the scope of taxpayer advice and assistance services provided by the customs and

tax administration. This expansion aims to enhance taxpayer access to legal information and establish effective mechanisms for preventing tax risks. For example:

- The Tax Administration will prepare and deliver manuals, guidelines, and recommendations tailored to the needs of taxpayers, incorporating information on common risks they face, and will involve them in both in-person and online training sessions;
- Organize relevant activities and provide recommendations to enhance taxpayers' tax education, prevent tax risks, and promote awareness of legislation;
- Based on taxpayers' requests for advisory and support services, organize discussions and training sessions involving other organizations, chambers of commerce, and professional associations, and publish related information on the Tax Administration's website;
- At the request of taxpayers, provide advice on tax registration, reporting, and payments, inform them of changes in tax legislation, and establish a system to offer guidance on the implementation of tax laws, exemptions, and reliefs using artificial intelligence and big data.

The amendments related to the aforementioned have been reflected in Article 1, Article 2, and Article 4 of the draft law, respectively.

- 2. Amendments Related to Supporting Taxpayer Compliance.** To encourage and reward responsible taxpayers and prevent them from the tax risks, the customs and tax administrations will assess the taxpayer compliance. A higher level of compliance will result in positive benefits such as the deferral of value-added tax payment deadlines, tax advisory services, and measures to prevent taxpayers from being subject to tax audits.

The amendments related to the aforementioned have been reflected in Article 1 and Article 2 of the draft law, respectively.

- 3. Amendments Related to Enhancing Coordination Between Customs and Tax Administrations, Ensuring Transparency, and Supporting Business Activities.** To foster a more business-friendly environment, the draft law introduces measures to harmonize the functions of customs and tax administrations, eliminate overlapping tax audits, enhance transparency, and refine regulations on tax reporting and payment documentation. Additionally, it includes provisions aimed at protecting taxpayers' rights and interests.

The amendments related to the aforementioned have been reflected in Article 1, Article 2, Article 3, Article 4, and Article 5 of the draft law, respectively.

- 4. Amendments to the Electronic Systems of Customs and Tax Administrations.** To enhance the implementation of customs and tax legislation, provide information and advice to taxpayers, citizens, and legal entities regarding tax incentives, and other related matters, the draft law proposes the use of an artificial intelligence and big data-based automated response system that operates 24/7. This will reduce human involvement and transition to a fully digitalized system.

The amendments related to the aforementioned have been reflected in Articles 1, 2, 3, 4, and 5 of the draft law